



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
УЛААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/54

Төгөл

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.1.11, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.4, 18.5, 20 дугаар зүйлийн 20.1 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Соёо багийн дээд Баян гэдэг газарт Галзуу өвчин гарч Хөвсгөл аймгийн лабораторийн 2024 оны 5 сарын 01-ний өдрийн 24-83 дугаартай шинжилгээний дүнгээр батлагдсан тул тухайн бүс нутагт 2024 оны 05 сарын 01-ний өдрөөс эхлэн 2024 оны 05 сарын 15 -ний өдөр хүртэл хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2. Хязгаарлалтын дэглэм тогтоосон бүс нутагт бод Галзуу өвчний зааврын дагуу ажиллаж, тандалт, эрт илрүүлгийн үзлэг хийж, хашаа хороонд халдваргүйтгэл хийж, вакцинжуулалт хийж ажиллахыг Соёо багийн Малын эмч (С.Жаргал), Хүний эмч (Б. Цэнгэлбаяр)-д үүрэг болгосугай.

3. Хязгаарлалтын дэглэм тогтоосон үед шаардагдах хүн хүч, харуул хамгаалалт гаргах, малын шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, үхсэн зэрлэг амьтны сэг зэмийг цуглуулж, устгал хийх арга хэмжээ авч ажиллахыг багийн Засаг дарга (С. Мягмардорж)-д даалгасугай

4. Уг арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах шатахууны зардлыг Орон нутгаас тооцож олгохыг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Батцогт), Нягтлан бодогч (Т. Намжилсүрэн) нарт даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (М. Батцогт)-д даалгасугай.

ДАРГА  Н.БАТБАЯР

/Zahiramj/